


БАТЛАВ
“ДБЭХС”ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР



2020.02.19

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**НАРИЙН ХЭМЖҮҮР НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Нарийн хэмжүүр нийлүүлэх**

Харьцуулалт/
Гэрээний дугаар: **ДБЭХС/202001078**

Чойбалсан хот 2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020.02.21

Төслийн нэр: **Нарийн хэмжүүр нийлүүлэх**

Харьцуулалт /гэрээний дугаар: **ДБЭХС/202001078**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нарийн хэмжүүр** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон харьцуулалтын баримт бичгийг www.tender.gov.mn хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50,000 төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Үнийн саналыг **[2020 оны 03 дугаар сарын 06 ны өдрийн 10:00 цаг]**-аас өмнө **Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03 дугаар сарын 06** ны өдрийн **[10:20]** -т нээнэ.

Үнийн санал ирүүлэхдээ барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг
“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төв байр
Утас: 70584545, 99076484, 89005447
Факс: 70584545

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> ➤ 2018, 2019 оны санхүүгийн тайлан ➤ 2018, 2019 онд үйлдвэрийн хэмжих хэрэгсэл, автомат удирдлага, түүний бүрдэл элементүүд нийлүүлсэн туршлагатай байх /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; ➤ Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ➤ 2018, 2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс дээш байх /Цахимаар ирүүлэх/ ➤ Татварын албаны тодорхойлолт /Цахимаар ирүүлэх/ ➤ Шүүхийн тодорхойлолт ➤ Тендерт ирүүлэх бүх лавлагаа, тодорхойлолт нь тендер зарласан өдрөөс хойш авсан байх шаардлагатай. ➤ Татвар төлөлтийн талаар лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдэл ирүүлэх. ➤ Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. ➤ Тендерт оролцогч өгөгдсөн техникийн тодорхойлолтыг мөрдөнө. Тендерийн баримт бичгийн 5,6-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. <p><i>/Тендерийн бичиг баримтыг дутуу бүрдүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно/</i> Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх:</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>2020 оны 03 дугаар сарын 06 ны өдөр 10 цаг 00 минут</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мб-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Мб-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорнод аймаг Хэрлэн сум 1 дүгээр баг “ДБЭХС”ТӨХК-ийн төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Үйлдвэрийн Б корпус 2 дугаар давхар К-ДХА цехийн даргын өрөө</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 06 ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 20 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Нарийн хэмжүүр (бараа) бүхий нэг багцаас бүрдэнэ.</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

БАТГАВ

Ө.ЖАРГАЛСАЙХАН

К-ДХА ЦЕХИЙН 2020 ОНД ХУДАЛДАН АВАХ НАРИЙН ХЭМЖҮҮРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020.01.20

Хэрлэн сум

Д/д	Материалын жагсаалт	Үзүүлэлт	Х/н	Тоо	Тайлбар
1	Зөөврийн халууны хэмжүүр	Маяг: GTH 1170 дүйцэхүйц Хязгаар: -65 ... 1150°C Анхдагч: Стандарт К төрөл Ажлын биеийн урт: 800-1200мм Ажлын биеийн диаметр: 3мм, 6мм Хийц материал: PVC Алдааны анги: A(I) /0.05%/ Нарийвчлал: 0.1°C Хамгаалалт: IP54	ш	2	
2	Тусгаарлагчын эсэргүүцэл хэмжигч	Маяг: UNI-T UT502A дүйцэхүйц Хязгаар: 0-2500V AC Туршилтын хүчдэл: 500V AC Тэжээл: 6X1.5V AA Нарийвчлал: full scale +/-5%/	ш	1	
3	Гүйдлийн хэмжүүр	Маяг: FLUKE 771 дүйцэхүйц Төрөл: CLAMP METER Хэмжих хязгаар: 4-20mA, 24V DC Алдаа: 0.2%	ш	1	
4	Термопар	Маяг: WIKA дүйцэхүйц Хязгаар: 0-1200°C Төрөл: K Ажлын бие урт: 1200 мм Ажлын бие диаметр: 8мм Алдааны ангилал: A(I)	ш	1	
5	Халууны датчик	Маяг: WIKA дүйцэхүйц Хязгаар: 0-600°C Төрөл: PT100 Ажлын бие урт: 300 мм Ажлын бие диаметр: 6мм Алдааны анги: A(I) Хамгаалалтын зэрэг: IP54	ш	4	
6	Халууны датчик	Маяг: WIKA дүйцэхүйц Хязгаар: 0-300°C Төрөл: PT100 Ажлын бие урт: 400 мм Ажлын бие диаметр: 6мм Алдааны анги: A(I) Хамгаалалтын зэрэг: IP54	ш	2	
7	Халууны датчик	Маяг: WIKA дүйцэхүйц Хязгаар: -40'...300°C Төрөл: PT100 Ажлын бие урт: 200 мм Ажлын бие диаметр: 6-10мм Алдааны анги: A(I) Хамгаалалтын зэрэг: IP54	ш	2	

8	Халууны хувиргагч	Маяг: SENSYCON Contrans TR04 ECO дүйцэхүйц Хязгаар: 0...1200°C Мэдрэгч: К Хувиргагч гаралт:4-20мА, 24V Хэлбэр: Head mount	ш	6	
9	Халууны хувиргагч	Маяг: SENSYCON Contrans TR04 ECO дүйцэхүйц Хязгаар: 0...600°C Мэдрэгч: PT100 Хувиргагч гаралт:4-20мА, 24V Хэлбэр: Head mount Алдааны ангилал: A(I)	ш	9	
10	Халууны хувиргагч	Маяг: SENSYCON Contrans TR04 ECO дүйцэхүйц Хязгаар: 0...300°C Мэдрэгч: PT100 Хувиргагч гаралт:4-20мА, 24V Хэлбэр: Head mount Алдааны ангилал: A(I)	ш	1	
11	Даралтын датчик	Маяг: STK131 дүйцэхүйц Хязгаар: 0-100 бар Хувиргагч гаралт:4-20мА, 24V Сигналын холбогч: DIN 43650 Холболт: M20X1.5 Алдаа: +/-0.2%/ Хамгаалалтын зэрэг: IP65	ш	3	
12	Даралтын датчик	Маяг: STK131 дүйцэхүйц Хязгаар: 0-25 бар Хувиргагч гаралт:4-20мА, 24V Сигналын холбогч: DIN 43650 Холболт: M20X1.5 Алдаа: +/-0.2%/ Хамгаалалтын зэрэг: IP65	ш	4	
13	Даралтын датчик	Маяг: STK131 дүйцэхүйц Хязгаар: 0-10 бар Хувиргагч гаралт:4-20мА, 24V Сигналын холбогч: DIN 43650 Холболт: M20X1.5 Алдаа: +/-0.2%/ Хамгаалалтын зэрэг: IP65	ш	2	
14	ЭКМ	Маяг: Хязгаар: 0-60 кгс/см2 Контакт төрөл: 2NO+2NC Чадал: 6А, 220V AC Холболт: M20X1.5 Алдаа: +/-0.2%/ Хамгаалалтын зэрэг: IP54	ш	1	
15	Тоон оролтын модуль	Маяг: SIEMENS 6ES7221-1BH32-0XB0 , SM-1221 дүйцэхүйц Хүчдэл: 24 V DC Сувгын тоо: 16 DI Программ: V13 SP1 portal software Хувилбар: e-Class 5.1	ш	2	

16	Контроллер	<p>Маяг: SIEMENS 6ES7211-1HE40-0XB0 , S7-1200 дүйцэхүйц Төрөл: PLC Тэжээл: 20.4 ... 28.8 V DC Тоон оролт: 6DI 24V DC Тоон гаралт: 4 DO, 2A relay Аналаг оролт: 2 AI , 0-10 V DC Багтаамж: 50KB Программ: V13 SP1 portal software</p>	ш	1	
17	Тоон гаралтын модуль	<p>Маяг: SIEMENS6ES7222-1HH32-0XB0 , SM-1222 дүйцэхүйц Хүчдэл: 24 V DC Тоон гаралт: 16 DO, 2A Программ: V13 SP1 portal software Хувилбар: e-Class 5.1</p>	ш	3	
18	Удирдлагын дэлгэц	<p>Маяг: SIEMENS 6AV2123-2GB03-0AX0 ,KTP700 дүйцэхүйц Тэжээл: 20.4 ... 28.8 V DC Хэмжээ: 7", TFT Удирдлага: touch control Өнгө: 65536 өнгө Программ: V13 SP1 portal software Хувилбар: e-Class 5.1</p>	ш	1	
19	Гибки кабель	<p>Маяг: LAPP LIYCY дүйцэхүйц Хөндлөн огтлол: 24X0.75 мм2 Материаль: Зэс Төрөл: Уян, экрантай Ажиллах температур: -20...80°C Хамгаалалт: Shielded 1000V, Чийгний хамгаалалт: хамгаалалттай</p>	м	200	
20	Гибки кабель	<p>Маяг: LAPP LIYCY дүйцэхүйц Хөндлөн огтлол: 12X0.75 мм2 Материаль: Зэс Төрөл: Уян, экрантай Ажиллах температур: -20...80°C Хамгаалалт: Shielded 1000V, Чийгний хамгаалалт: хамгаалалттай</p>	м	200	
21	Гибки кабель	<p>Маяг: LAPP LIYCY дүйцэхүйц Хөндлөн огтлол: 5X2.5 мм2 Материаль: Зэс Төрөл: Уян, экрантай Ажиллах температур: -20...80°C Хамгаалалт: Shielded 1000V, Чийгний хамгаалалт: хамгаалалттай</p>	м	300	

22	Гибки кабель	Маяг: LAPP LIYCY дүйцэхүйц Хөндлөн огтлол: 3X0.5 мм ² Материаль: Зэс Төрөл: Уян, экрантай Ажиллах температур: -20...80°C Хамгаалалт: Shielded 1000V, Чийгний хамгаалалт: хамгаалалттай	м	400	
ДҮН					

ХЯНАСАН:

ТХА-НЫ ДАРГА

Т.ТӨМӨРБААТАР

ИА-НЫ ДАРГА

Б.БЯМБАА

ИА-НЫ АХЛАХ ИНЖЕНЕР

М.СЭНГЭДОРЖ

ГАРГАСАН:

К-ДХА ЦЕХИЙН ДАРГА

Я.НАРАНБААТАР

2. **Стандарт:** Нарийн хэмжүүрүүд нь үйлдвэрийн гарал үүслийн бичигтэй, ашиглалтын заавар схемтэй (Англи хэл дээр) байна. Нарийн хэмжүүрүүд нь лабораторид тест хийгдэж баталгаажсан байх ба шалгаж туршсан акт протокол хавсаргана. Бүх хэмжих хэрэгслүүд үйлдвэрийн 1 жилээс багагүй баталгаатай байна.
3. **Баглаа, боодол:** Нарийн хэмжүүрүүд нь үйлдвэрийн лацтай, доргионы хамгаалалтай сав баглаа боодолтой байна.
4. **Бараа хүргэх газар:** “ДБЭХС”ТӨХК-ийн төв агуулах
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Нарийн хэмжүүрүүдийг гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлэх

Нарийн хэмжүүр нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хуртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
<i>[Дугаар бичих]</i>	<i>[Барааны товч тодорхойлолтыг бичих]</i>	<i>[нэгжийн тоо ширхэгийг бичих]</i>	<i>[Хэмжих нэгжийг бичих]</i>	<i>[Бараа хүргэх газрын нэр]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>
1	Зөөврийн халууны хэмжүүр	ш	2	"ДБЭХС" ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлэх	Гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлэх	
2	Тусгаарлагчын эсэргүүцэл хэмжигч	ш	1				
3	Гүйдлийн хэмжүүр	ш	1				
4	Термопар	ш	1				
5	Халууны датчик	ш	4				
6	Халууны датчик	ш	2				
7	Халууны датчик	ш	2				
8	Халууны хувиргагч	ш	6				
9	Халууны хувиргагч	ш	9				
10	Халууны хувиргагч	ш	1				
11	Даралтын датчик	ш	3				

12	Даралтын датчик	ш	4	“ДБЭХС” ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлэх	Гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлэх	
13	Даралтын датчик	ш	2				
14	ЭКМ	ш	1				
15	Тоон оролтын модуль	ш	2				
16	Контроллер	ш	1				
17	Тоон гаралтын модуль	ш	3				
18	Удирдлагын дэлгэц	ш	1				
19	Гибки кабель	м	200				
20	Гибки кабель экрантай	м	200				
21	Гибки кабель	м	300				
22	Гибки кабель	м	400				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Нарийн хэмжүүрүүдийг хүлээн авахдаа үйлдвэрийн лабораторид шалгасан акт, протоколыг үндэслэл болгоно.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[100]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- 9.1. Алданги оногдуулах хувь: ***Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн [0,5] хувь***
- Алдангийн нийт дүн: ***Гэрээний нийт үнийн [10] хувиас хэтрэхгүй***

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]